

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС
ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ
БАТАЛСААР БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2024/28-21-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 89100230 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

Н.Гүрбазар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2024 оны 05 дугаар сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

Бүлэг А. Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ төлөвлөн баталснаас 3 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 341.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй байна.

А.2. Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ төлөвлөн баталснаас 3 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 341.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

А.3. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ баталсны улмаас худалдан авах ажиллагааг дунджаар 56 өдрөөр хугацаа хоцроож зохион байгуулсан байна

Бүлэг Б: Захиалагчийн хяналт нь гэрээний хариуцлагыг тооцож ажиллахгүй байгаагаас гэрээний хугацаа хоцрох, ажлыг зураг, төсвийн дагуу гүйцэтгэхгүй байх зэрэг зөрчил давтагдан гарсаар байна.

Б.1. Захиалагчийн хяналт нь гэрээний хариуцлагыг тооцож ажиллахгүй байгаагаас гэрээний хугацаа хоцрох, ажлыг зураг, төсвийн дагуу гүйцэтгэхгүй байх зэрэг зөрчил давтагдан гарсаар байна.

Б.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Б.3. Төсөл, арга хэмжээнд холбогдох хууль, журмын дагуу хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Б.4. Орон нутгийн өмчийн газар нь өмчийн талаарх чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй байна.

Бүлэг В: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 89 хувийг хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байна.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 89 хувийг хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байна.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлийн талаарх мэдээллийг khovsgol.gov.mn, shilendans.gov.mn цахим сайтуудад тогтмол оруулж ажилласан байна

В.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Тайлангийн хавсралтууд

Холбогдох байгууллагуудын санал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/12

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол улсын Ерөнхий аудиторов 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагуудыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга, Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвийн дарга нарт хүргүүлсүгэй.

3. “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлтийг 2024 оны 12 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Мөнгөнхуяг), аймгийн Засаг дарга (П.Лхагважав), Засаг даргын тамгын газрын дарга (Б.Батбилгүүн), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал (Х.Даваасүрэн) нарт даалгасугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.


6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



6724010034



Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 05 дугаар сарын 25-ний өдрийн 4/12 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

д/д	Акт, албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Акт, албан шаардлагын дугаар
1	Зөрчил арилгах тухай	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	81/A2270437/ ХӨА-2024/28-21-ШТА-ГА
2	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	82/A2270437/ХӨА-2024/28-21-ШТА-ГА
3	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	83/A2270438/ХӨА-2024/28-21-ШТА-ГА
4	Зөрчил арилгах тухай	Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ	84/A2270437/ХӨА-2024/28-21-ШТА-ГА

--ooOoo--

Товчилсон үгийн тайлбар

АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗД	Аймгийн Засаг дарга
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨТАГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХШҮХ	Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх,
- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх,
- ❖ Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх,

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг 2023 онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд, хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, гүйцэтгэгч аж ахуй нэгж болон хяналтын чиг үүрэг бүхийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Арбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Тариалан, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Түнэл сумдын холбогдох төрийн байгууллага, ажлын хэсгийн үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэсэн.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлд хийх хяналтыг 3,863.4 сая төгрөгийн 23 төсөл, арга хэмжээ буюу нийт төсөвт өртгийн 85 хувьд гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Хөвсгөл аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний

харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд үндэслэн аудитын дүгнэлт, шийдвэрийг боловсрууллаа.

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн нийцлийн газрын даргын 2024.04.08-ны өдрийн 08/921 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг баримтлан гүйцэтгэсэн.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Н.Гүрбазар нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Хөвсгөл аймгийн 2023 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталж, тогтоолын 2 болон 6 дугаар хавсралтаар 4,110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тайлант онд 2,939.4 сая төгрөгөөр санхүүжих 27 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Төсвийн тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 2 дугаар хавсралтаар, их засварын ажлыг 6 дугаар хавсралтаар баталсан боловч эдгээр нь хөрөнгө оруулалтын дансны зардал тул нийлүүлэн аудитад хамрууллаа.

Орон нутгийн төсөвт аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар тодотгол хийж, тодотголоор дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнд:

1. Нийтийн зориулалттай орон сууцны узель, шугам сүлжээг шинэчлэх ажил /Мөрөн сум 8 дугаар баг 18 дугаар байр/ - 68.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээг хассан,
2. Зургаадугаар багт хийгдсэн ариутгах татуурга, цэвэр бохир усны шугам сүлжээний байгууламжийн траншейны нүхийг таглах, овгор шороонуудыг тэгшлүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тайлант онд санхүүжих дээрх дүнгээр мөн нэмэгдүүлж 32.4 сая төгрөг болгосон,
3. Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин тоног төхөөрөмжийг хадгалах байр засварлах ажлын зөвлөх үйлчилгээний зардал 1.2 сая төгрөг баталсан,
4. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн албан хаагчдын орон сууцны засвар, өргөтгөл хийх 40.0 төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 14.0 сая төгрөгөөр нэмж тайлант онд санхүүжих дүнг 40.0 сая төгрөг болгосон,
5. Мод тарьж, Ногоон суварга босгох ажлын хүрээнд хашаа хайс барих, шинэчлэх /Мөрөн сум/ - 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 45.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 345.0 сая төгрөг болгосон,
6. "Хүүхдийн өрөө"-ний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Шүүхийн тамгын газар/ - 29.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг шинээр нэмсэн,
7. "Соёлын төвийн барилгын их засвар /Галт сум/" – 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний нэршлийг "Ерөнхий боловсролын сургуулийн 50 хүүхдийн дотуур байрны их засвар" гэж өөрчилсөн,
8. Их засварын 5 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 494.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Төсвийн тодотголын дараах дүнгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,566.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2023 онд 2,963.1 сая төгрөгөөр санхүүжих 28 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр АИТХ-аас тогтоосон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний 2,149.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээ нь 2023 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт байна.


Тайлант онд баталсан хөрөнгө оруулалтын төрлийг төсөвт өртөг, санхүүжилтийн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №1

Хөрөнгө оруулалтын төрөл	Тоо	Төсөвт өртөг	2023 онд баталсан санхүүжилт	2023 оны санхүүжилтэд эзлэх хувь
Барилга, байгууламж	4	817.0	521.0	18%
Их засвар	20	3,608.9	2,301.4	78%
Тоног төхөөрөмж	2	59.5	59.5	2%
ТЭЗҮ	2	81.2	81.2	3%
Дүн	28	4,566.6	2,963.1	100%

Хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, баталсан санхүүжилтийг салбараар/график №1/ ангилан харуулбал байдалтай байна.

График №1



Тайлант онд 4,245.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалтыг зохион байгуулж **51.3** сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна.


БҮЛЭГ А:

ЗУРАГ, ТӨСӨВГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨН БАТАЛСНААС 3 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ 341.2 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДСЭН БАЙНА.

А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 2,041.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээг шилжих хөрөнгө оруулалтаар, 2,525.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж аймгийн ИТХ-аас баталсан байна. /Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалт, төсөвт өртөг, санхүүжих дүнг хавсралт №1-ээр харуулав/

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг Төрийн хэмнэлтийн тухай хууль болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн төлөвлөсөн боловч төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангуулаагүй байна. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний тоог графикаар харуулбал дараах байдалтай байна. /Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт №2-оор харуулав/ Үүнд:



Графикаас харахад шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээнүүд нь батлагдсан зураг төсөвтэй байх, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байх, урсгал зардал тооцсон байх, өмчлөлд бүртгэх боломжтой байх зэрэг Төсвийн тухай хуулийн 29, 29¹¹ дүгээр зүйлд заасан хуулийн шаардлагыг хангаагүй байна.

Тайлант онд шинээр болон үргэлжлэн хэрэгжсэн 2,906.7 сая төгрөгийн 16 барилга, байгууламж, их засварын ажлыг батлагдсан зураг, төсөвгүй төлөвлөж, баталсан байна. Төсөвт өртөг, санхүүжилтийг зураг, төсвийн үндэслэлгүй тооцож баталснаас шалтгаалан зарим төсөл, арга хэмжээний ажлын төсөвт зайлшгүй хийгдэх ажлын зардал тусгагдаагүй байх, ажлын төсвийг хэт бага үнээр тооцсон байх зэрэг сөрөг нөлөөг үзүүлж байна. Тухайлбал:

1. Хаш тулгуур ХХК-ийн гүйцэтгэсэн Спорт, соёлын өргөөний барилгын дээврийн засвар /Биеийн тамир спортын газар/ төсөл, арга хэмжээний зурагт дээврийн өөхийвчийн ажлыг тусгаагүйгээс төсөвт тус ажлын зардлыг тооцоогүй, гүйцэтгэгч төсөвт байхгүй ажил гүйцэтгэсэн байна.
2. Сант-Өндөр ХХК-ийн гүйцэтгэсэн 15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалтын ажил /Мөрөн сум/ төсөл, арга хэмжээний шалны халаалтын материалын зардлыг төсөвт тусгаагүйгээс гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэсэн байна.

¹ 29¹.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

29.2.Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

3. Уул өвгөд ХХК-ийн гүйцэтгэсэн Мод тарьж, Ногоон суварга босгох ажлын хүрээнд хашаа хайс барих шинэчлэх /Мөрөн сум, 8 дугаар баг/ төсөл, арга хэмжээний зургийг боловсруулахдаа төсөл хэрэгжих талбайн чөлөөлөлт, дулааны шугамын болон цахилгаан дамжуулах төвийн аюулгүй ажиллагааны зааг, талбайн хэмжээг зөв тооцоогүйгээс ажлыг гүйцэтгэхэд хашааны байрлалыг өөрчлөх, ажлын тоо хэмжээ өөрчлөгдөх зэрэг төлөвлөгдөөгүй нэмэлт ажлууд хийгдсэн байна.

Дээрх зөрчлүүд нь захиалагч Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-т заасан “барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх;” чиг үүргээ бүрэн биелүүлээгүйгээс шалтгаалан гарсан байна.

Мөн дараах төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжих хугацааг үндэслэлгүй тооцож, шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтыг шилжих хөрөнгө оруулалтаар тооцож баталсан байна. Үүнд:

- 6 дугаар багт хийгдсэн ариутгах татуурга, цэвэр бохир усны шугам сүлжээний байгууламжийн траншейны нүхийг таглах, овгор шороонуудыг тэгшлүүлэх /төсөвт өртөг - 32.4 сая төгрөг/,
- Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн албан хаагчдын орон сууцны засвар, өргөтгөл хийх /төсөвт өртөг - 40.0 сая төгрөг/

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.2.1² дэх заалттай нийцээгүй байна.

А.2. Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ төлөвлөн баталснаас 3 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 341.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмнөх оноос шилжин хэрэгжиж буй 2,041.0 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнээс 503.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний 213.7 сая төгрөгийн үлдэгдэл бүрэн санхүүжилт, 1,537.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний 756.8 сая төгрөгийн хэсэгчилсэн санхүүжилтийг баталсан бол шинээр хэрэгжсэн 2,525.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээнээс 1,352.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээний бүрэн санхүүжилт, 1,172.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний 640.0 сая төгрөгийн хэсэгчилсэн санхүүжилтийг баталжээ. Дээрх дүнгээс үзэхэд 900.8 сая төгрөгийн хэсэгчилсэн санхүүжилт буюу нийт төсөвт өртгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт дараа онд шилжсэн байна.

Дараах шалтгаанаар санхүүжилтүүд дараа онд шилжсэн байна. Үүнд:

1. Зураг, төсөвгүй 4 төсөл, арга хэмжээг 540.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төлөвлөн батлуулсан боловч батлагдсан зураг, төсвийн дагуу төсвийн тодотголоор төсөвт өртөг 491.4 сая төгрөгөөр нэмэгдэж Хөвсгөл аймгийн 2024 оны төсөвт 3 төсөл, арга хэмжээний 341.2 сая төгрөгийн санхүүжилт шилжин батлагдсан байна. Дээрх санхүүжилт нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹2.2³-т заасны дагуу баталгаажсан зураг, төсөвтэй төсөл, арга хэмжээ төлөвлөн, батлаагүйгээс шалтгаалан дараа онд шилжсэн байна.
2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар 1,037.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ нь 2022 онд 250.6 сая төгрөг, 2023 онд 411.8 сая төгрөг, 2024 онд төсөл, арга хэмжээ нь 374.9 сая төгрөгийн хэмжээнд тус тус хэрэгжиж байгаа бөгөөд нэгдсэн зураг, төсөвгүй жил бүр аймгийн төсөв батлагдсанаас хойш хийгдэх ажлыг тодорхойлж зураг, төсвийг тухайн үед нь хийлгэж байгаа нь гүйцэтгэлийн шатанд ажлын тоо, хэмжээ өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөг үзүүлж байна.
3. Өмнөх оноос шилжин хэрэгжиж буй 500 сая төгрөгийн төсөв өртөгтэй Мод тарьж, Ногоон суварга босгох ажлын хүрээнд хашаа хайс барих шинэчлэх төсөл, арга

² “орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, дтайлагнах;”

³ 29¹2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

хэмжээний үлдэгдэл 144.6 сая төгрөгийн санхүүжилт гэрээнд заасны дагуу дараа онд шилжсэн байна.

4. Мөрөн сумын 15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалт 141.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний 40.0 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилт гэрээнд заасны дагуу дараа онд шилжсэн байна.

Хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүйгээс 4 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 491.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 3 төсөл, арга хэмжээний 341.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт дараа онд шилжин батлагдсан байна. Иймд хөрөнгө оруулалтын санхүүжилтийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна гэж дүгнэлээ.

А.3. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ баталсны улмаас худалдан авах ажиллагааг дунджаар 56 өдрөөр хугацаа хоцроож зохион байгуулсан байна

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг АИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08 дугаар баталж, 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хийсэн орон нутгийн төсвийн тодотголоор төсвийн тодотголд хамаарах арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэмж баталсан байна.

Аймгийн ХААГ нь 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 25 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 23 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж үүнээс 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэн зохион байгуулсан байна.

Дараах шалтгааны улмаас 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. **Үүнд:**

- Ахмадын амралт, сувиллын байрыг төвийн дулааны шугамд холбох /Мөрөн сум/ төсөл арга хэмжээ зураг, төсөвгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй,
- Ерөнхий боловсролын сургуулийн 50 хүүхдийн дотуур байрны их засвар төсөл, арга хэмжээ нь зураг, төсөвгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд зааснаар 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн зохион байгуулахаар байсан боловч зураг, төсөв, техникийн тодорхойлолтгүйн улмаас төлөвлөсөн хугацааг мөрдөөгүй дунджаар 56 өдрөөр хоцроож зохион байгуулсан байна.

Хугацаа хоцорсон зөрчлийг эс тооцвол худалдан ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажилласан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй, зураг төсөвгүй баталсны улмаас худалдан авах ажиллагаа төлөвлөгөөнд заасан хугацаанд зохион байгуулагдаагүй, санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн, гүйцэтгэгч зураг төсөвт заагаагүй ажлыг өөрийн зардлаар гүйцэтгэсэн зэрэг нөхцөл байдал илэрч байна. Төрийн аудитын газраас Хөвсгөл аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангахгүй, зураг төсөвгүй байгаа тул хуулийн хэрэгжилтийг хангуулах зөвлөмжийг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг дарга нь хөрөнгө оруулалтыг хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөх, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтыг хянан, батлах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаагаас худалдан авах ажиллагаа хугацаа хоцрох, төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэх, барилгын ажлын төсөв бүрэн бус байх, төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байх зэрэг сөрөг үр нөлөөг үзүүлж байна.

БҮЛЭГ Б:

ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ НЬ ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГЫГ ТООЦОЖ АЖИЛЛАХГҮЙ БАЙГААГААС ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА ХОЦРОХ, АЖЛЫГ ЗУРАГ, ТӨСВИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭХГҮЙ БАЙХ ЗЭРЭГ ЗӨРЧИЛ ДАВТАГДАН ГАРСААР БАЙНА.

Б.1. Захиалагчийн хяналт нь гэрээний хариуцлагыг тооцож ажиллахгүй байгаагаас гэрээний хугацаа хоцрох, ажлыг зураг, төсвийн дагуу гүйцэтгэхгүй байх зэрэг зөрчил давтагдан гарсаар байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр баталсан 4,566.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээнээс 4,245.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл, арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн бол худалдан авах ажиллагаа явуулаагүй 320.7 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламжийн ажилд Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, бусад ажилд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг/комисс/ хяналт хэрэгжүүлж ажиллажээ.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт хийхэд хугацаандаа гүйцэтгэгдээгүй болон зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хийгдээгүй дараах асуудлууд илэрч байна. Үүнд:

Хугацааны хувьд:

- 1) Хаш тулгуур ХХК-ийн гүйцэтгэсэн Спорт, соёлын өргөөний барилгын дээврийн засвар /Биеийн тамир спортын газар/ төсөл, арга хэмжээг гэрээнд зааснаар 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр гүйцэтгэж дуусах ёстой байсан боловч 2023 оны 10 дугаар сарын 18—ны өдөр гэрээ сунгаж 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ажлыг дуусгаж, 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Ажил гүйцэтгэх хугацаа хоцорсон зөрчилд ХБТХОХ, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв нь гэрээний хариуцлага тооцож ажиллаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.2.4⁴, Ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 10.22⁵ дахь заалтуудтай тус нийцэхгүй байна. /Гүйцэтгэгч нь зураг, төсөвт заагаагүй дээврийн өөхийвчний ажил гүйцэтгэсэн тул хариуцлага тооцоогүй болно./
- 2) Талын хөх сувд ХХК гүйцэтгэж буй “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн албан хаагчдын орон сууцны засвар, өргөтгөл хийх” төсөл, арга хэмжээний ажлыг гэрээнд зааснаар 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор гүйцэтгэж хүлээлгэн өгөх ёстой байсан боловч одоог болтол хэрэгжиж дуусаагүй байна. Энэ нь 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан засварын ажлын гэрээний 1.4⁶ дахь заалттай нийцэхгүй байна.
- 3) Сант-Өндөр ХХК-ийн гүйцэтгэж буй 15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалтын ажил /Мөрөн сум/ төсөл, арга хэмжээ нь гэрээний дагуу 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хэрэгжиж дуусах ёстой байсан боловч тайлант онд хэрэгжиж дуусаагүй байна. Энэ нь 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний 2⁷ дахь заалттай нийцэхгүй байна.

Зураг, төсөв, техникийн шаардлагын хувьд:

1. Сант-Өндөр ХХК-ийн гүйцэтгэсэн 15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалтын ажил /Мөрөн сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг зураг, төсөвтэй тулган хянахад бүлгийн өрөөнд угаалтуур байршуулах, угаалгын өрөөнд хамар хана өрөх ажлыг гүйцэтгээгүй гүйцэтгээгүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Барилгын материал, бүтээгдэхүүнийг барилгын ажлын явцад захиалагч, гүйцэтгэгчийн хүсэлтийг

⁴ 2.3.2.4. төсөл, арга хэмжээний гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу хяналтын хуудас хөтлөх;

⁵ Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Ажил дуусах хугацааг гэрээнд заасан өдрөөс хоцроосон тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлнө.

⁶ “Гүйцэтгэгч нь Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд байрлалтай төрийн албан хаагчийн байрны засварын ажлыг 2023 оны 08.07-нд эхэлж 2023.12.20-нд ашиглалтанд оруулна. ...”

⁷ “Энэхүү гэрээт ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор дуусгаж ашиглалтад оруулна. ...”

үндэслэн зураг төсөл зохиогчийн шийдвэрээр өөрчилнө.”, 37.4-т “Захиалагч барилга байгууламжийн зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.” гэж заасантай тус тус нийцээгүй байна. Иймд барилгын баталгаат хугацаанд зөрчлийг арилгуулах албан шаардлагыг Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-т хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Өмнөх онуудад гүйцэтгэсэн аудитууд болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн аудитын дүнгээс харахад захиалагчийн хяналт нь гүйцэтгэгчид гэрээний хариуцлагыг тооцож ажиллахгүй байгаагаас гэрээний хугацаа хоцрох, ажлыг зураг, төсвийн дагуу гүйцэтгэхгүй байх зэрэг зөрчил давтагдан гарсаар байна.

Б.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр баталсан 4,566.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2,963.1 сая төгрөгөөр санхүүжих 28 төсөл, арга хэмжээнээс 4,466.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээнд 2,742.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. /хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг хавсралт № 3 –оор харуулав./ Үүнээс 21 төсөл, арга хэмжээний 123.9 сая төгрөгийг барьцаа, 1 төсөл, арга хэмжээний 8.0 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Аудитаар санхүүжилттэй холбоотой зөрчил илрээгүй ба хөрөнгө оруулалтын санхүүжилтийг ажлын гүйцэтгэл, холбогдох хяналтын дүгнэлтийг үндэслэн олгосон байна.

Б.3. Төсөл, арга хэмжээнд холбогдох хууль, журмын дагуу хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант онд хэрэгжсэн 4,245.9 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээнээс 3,901.2 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна. Бүлэг Б.1-т дурдсан зөрчлийг эс тооцвол хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд барилга захиалагчийн хяналт, төслийн баг, холбогдох хууль, журмын дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Харин аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь хууль, журамд заасан чиг үүргийн дагуу хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Б.4. Орон нутгийн өмчийн газар нь өмчийн талаарх чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар ашиглалтад хүлээн авсан 4,064.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээнээс 464.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 335.1 сая төгрөгийн засварын ажил, тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлд тусгасан бол 3,229.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээний хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлд бүртгэхгүй 371.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. /нягтлан бодох бүртгэлд тусгасан болон тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт № 4-өөр харуулав./

Ашиглалтад хүлээн авсан хөрөнгө оруулалтын 70 хувийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь аймгийн Орон нутгийн өмчийн газар Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.5.2⁸-т заасан чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн болохыг харуулж байна.

Зарим төсөл, арга хэмжээнүүдийг гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаа, зураг төсөв, техникийн шаардлагын дагуу гүйцэтгээгүй, захиалагч нь хяналтын чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй, ашиглалтад хүлээн авсан 3,229.2 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан

⁸ Энэ журмын 5.5.1-д заасан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх чиг үүргийг захиалагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж (ажилтан) хэрэгжүүлэх бөгөөд өмчид бүртгүүлэхийг тодорхойлох урьдчилсан маягтыг бөглөн цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтэд хамт ирүүлж, цахим системийн өмчийн санд мэдээллийн санг бүрдүүлнэ.

бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон хөрөнгийн үнэ цэнийг бууруулах, үрэгдэх эрсдэлийг бий болгож байна

БҮЛЭГ В:

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 89 ХУВИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД БАЙНА.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 89 хувийг хэрэгжүүлж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онуудад хэрэгжсэн 4,064.9 сая төгрөгийн төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээ буюу 89 хувийг байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Аудитаар ашиглалтад хүлээн авсан хөрөнгө оруулалтуудын ашиглалтад хяналт хийхэд зориулалтын дагуу ашиглаж байна.

Нийт хөрөнгө оруулалтын 11 хувь буюу 501.7 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй, гэрээний хугацаандаа хэрэгжиж дуусаагүй /тайлангийн А.3, Б.1-т дурдсан/ зэрэг шалтгаанаар төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлийн талаарх мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр ил тод мэдээлж ажилласан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дараах байдлаар олон нийтэд ил тод мэдээлж ажилласан байна. Үүнд:

1. Khovsgol.gov.mn сайтад орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээллийг сар тутам,
2. Shilendans.gov.mn цахим сайтад санхүүжилтийн мэдээллийг сар тутам.

В.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн аудитын газраас 2023 онд гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитаар 2 албан шаардлага, 8 албан тушаалтанд нийт 11 зөвлөмж хүргүүлсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож үзэхэд дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдан гарч байна. **Үүнд:**

- Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, саналд үндэслэсэн, нийцсэн, ач холбогдолтой, олон нийтийн саналыг авч эрэмбэлэгдсэн, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг батлах
- Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, саналд үндэслэсэн, ач холбогдолтой, олон нийтийн саналыг авч эрэмбэлэгдсэн, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг төлөвлөх
- Төсвийн хөрөнгө оруулалтад аудит хийж, үр дүнг сайжруулж ажиллах;
- Төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хийж үнэлгээ өгч ажиллах.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн аудитаар зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн тул аймгийн ИТХ, Засаг даргад зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дээрх зөвлөмжүүдээс гадна 2022 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн аудитаар өгсөн “Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд, хэрэгжилт үр дүнг хариуцах хууль, журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг захиалагч(Засаг дарга), чиг үүрэг бүхий Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс боловсруулаагүй зөрчил давтагдан гарсан байна. Тухайлбал:

1. “Хүүхдийн өрөө”-ний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Шүүхийн тамгын газар/ төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Шүүхийн тамгын газар, “Киоск” төхөөрөмж болон дагалдах хэрэгслийг худалдан авах /Газрын нэгдсэн систем Е-Монголиа/ төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар тус тус боловсруулсан.

2. 2024 онд хэрэгжүүлэхээр баталсан Тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Биеийн тамир спортын газар, Аймгийн Засаг даргын Тамгын газарт Тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт Авто машин худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Хууль эрх зүйн хэлтэс зэрэг өөр газар, хэлтсүүд боловсруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5⁹, 12 дугаар зүйлийн 12.1¹⁰ дэх заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа ба хөрөнгө оруулалтыг нэгтгэн удирдаж чадахгүй байх, хяналт тавигдахгүй байх зэрэг сөрөг нөлөөг бий болгох эрсдэлтэй байна. Аудитын явцад аймгийн Засаг даргын Тамгын газар нь хэлтсүүдийн чиг үүргийг бүрэн тодорхойлж, ажлын уялдааг хангаж ажиллаагүй байгаа нь дээрх зөрчил гарах бас нэг шалтгаан болж байна.

Аудитаар өгсөн асуудлын бүртгэлд Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь өөрсдөө техникийн тодорхойлолтуудыг боловсруулан ажиллаж байгаа гэсэн хариуг өгсөн боловч бодит байдалд техникийн тодорхойлолтыг боловсруулаагүй байгаа тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 89 хувийг хэрэгжүүлж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Аудитаар нийт 3,309.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 80.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, 3,229.2 сая төгрөгийн 5 зөвлөмжийг 6 байгууллага, албан тушаалтанд өгч ажиллалаа.

⁹ Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна.”

¹⁰ Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн Засаг дарга нь хөрөнгө оруулалтыг хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөх, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтыг хянан, батлах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаагаас өмнөх онуудад өгсөн зөвлөмж хэрэгжээгүй, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд нь төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байх үндсэн нөхцөлийг бий болгож байна.
2. Захиалагчийн хяналт нь гэрээний хариуцлагыг тооцож ажиллахгүй байгаагаас гэрээний хугацаа хоцрох, ажлыг зураг, төсвийн дагуу гүйцэтгээгүй зэрэг хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр нөлөөг тодорхой хэмжээнд бууруулж байна.
3. Ашиглалтад хүлээн авсан 3,229.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээний хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, Орон нутгийн өмчийн газар нь өмчийн талаарх чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байгаа нь хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон хөрөнгийн үнэ цэнийг бууруулах, үрэгдэх эрсдэлийг бий болгож байна.
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 89 хувийг хэрэгжүүлж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.
5. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь хэлтсүүдийн чиг үүргийг бүрэн тодорхойлж, ажлын уялдааг хангаагүйгээс хөрөнгө оруулалтын техникийн тодорхойлолтыг хариуцсан хэлтэс нь боловсруулаагүй, чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаа зөрчил давтагдан гарсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга П.Лхагважавт:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах;

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбилгүүнд:

1. Төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төлөвлөж ажиллах;
2. Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн чиг үүргийг тодорхой болгож, ажлын уялдааг хангах

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Цэнд-Аюушид:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах үр өгөөжийг сайжруулах;

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяад:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн төлөвлөх

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал Х.Даваасүрэнд:

1. Гэрээний хугацаанд дуусаагүй төсөл, арга хэмжээнүүдийн зөрчлийг арилгуулах, захиалагчийн хяналтын үр нөлөөг сайжруулах;

Зөрчлийн жагсаалт:

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэглэгчийн хэрэгцээ техникийн нөхцөл олгогдоогүй, шаардлагад үндэслээгүй, урсгал зардал тооцоогүй, нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй, байгууллагын өмчлөлд бүртгэх боломжгүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн зөрчил давтагдан гарч өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн хэрэгжүүлээгүй байна.	80.0			2	80.0	2	-
2	2 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн хэрэгжиж дуусаагүй.	-					1	-
3	Сант-Өндөр ХХК-ийн гүйцэтгэсэн 15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалтын ажил /Мөрөн сум/ төсөл, арга хэмжээний нэгдүгээр бүлгийн өрөөнд угаалтуур байршуулах, хамар ханын өрлөг өрөх зэрэг ажлыг гүйцэтгээгүй.	-			1	-		
4	Захиалагч, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй	-			1	-		
5	Засаг даргын Тамгын газар нь хэлтсүүдийн чиг үүргийг тодорхойлж, ажлын уялдааг хангасан баримт бичиггүй	-					1	-
6	Тайлант оны жилийн эцсийн байдлаар ашиглалтад хүлээн авсан 4,064.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээнээс 3,229.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээний хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна	3,229.2					2	3,229.2
НИЙТ ДҮН		3,309.2			4	80.0	6	3,229.2

Хавсралт №1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний төрөл	Шинээр эхлэх, шилжих эсэх	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар	их засвар	шилжих	1,037.4	411.8
2	Ахмадын амралт, сувиллын байрыг төвийн дулааны шугамд холбох /Мөрөн сум/	их засвар	шинэ	220.7	70.0
3	Эрүүл мэндийн төвийн гадна бохирын шугамын цооногийн ажлын засвар/Тосонцэнгэл сум/	их засвар	шинэ	80.0	80.0
4	Ерөнхий боловсролын сургуулийн бага сургуулийн засвар, дулаалга хийлгэх/Хатгал тосгон/	их засвар	шинэ	415.5	300.0
5	Эрүүл мэндийн төв, Спорт заалны сантехник тавих засвар хийх /Бүрэнтогтох сум, Бүрэнхаан баг/	их засвар	шинэ	262.6	100.0
6	Гурван гал ӨЗМТ-ийн барилгын дотор сантехник, гадна бохир, усны шугам, сүлжээний их засвар	их засвар	шинэ	19.1	19.1
7	Соёлын төвийн дээврийн их засвар /Цагаан-Уул сум/	их засвар	шинэ	100.0	100.0
8	Спорт заалны дээврийн их засвар /Цагаан-Уул сум/	их засвар	шинэ	133.2	70.0
9	Цэцэрлэгийн сантехникийн их засвар /Хатгал тосгон/	их засвар	шинэ	30.0	30.0
10	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин тоног төхөөрөмжийг хадгалах байрны засварын дуусгалт /Орон нутгийн өмчийн газар/	их засвар	шилжих	6.0	6.0
11	Соёлын төвийн барилгын их засвар /Баянзүрх сум/	их засвар	шинэ	65.0	65.0
12	Ерөнхий боловсролын сургуулийн 50 хүүхдийн дотуур байрны их засвар	их засвар	шинэ	100.0	100.0
13	Спорт, соёлын өргөөний барилгын дээврийн засвар /Биеийн тамир спортын газар/	их засвар	шинэ	201.4	201.4
14	Аймгийн төвийн Нэгдсэн эмнэлгийн их засвар	их засвар	шинэ	375.7	375.7
15	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах	барилга байгууламж	шилжих	156.5	56.5
16	Цэцэрлэгийн гал тогооны засвар /Хатгал тосгон/	их засвар	шилжих	50.0	50.0
17	Мод тарьж, Ногоон суварга босгох ажлын хүрээнд хашаа хайс барих шинэчлэх /Мөрөн сум, 5 дугаар баг/ Мод тарьж, Ногоон суварга босгох ажлын хүрээнд хашаа хайс барих шинэчлэх /Мөрөн сум, 8 дугаар баг/	барилга байгууламж	шилжих	500.0	345.0
18	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засварын ажлын дуусгалт /Мөрөн сум 8 дугаар баг 15 дугаар байр/	их засвар	шилжих	145.0	45.0
19	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засварын ажлын дуусгалт /Мөрөн сум 8 дугаар баг 16 дугаар байр/	их засвар	шилжих	145.0	55.0
20	6 дугаар багт хийгдсэн ариутгах татуурга, цэвэр бохир усны шугам сүлжээний байгууламжийн траншейны нүхийг таглах, овгор шороонуудыг тэгшлүүлэх	их засвар	шинэ	32.4	32.4
21	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн албан хаагчдын орон сууцны засвар, өргөтгөл хийх	их засвар	шинэ	40.0	40.0
22	"Киоск" төхөөрөмж болон дагалдах хэрэгслийг худалдан авах /Газрын нэгдсэн систем Е-Монголиа/	тоног төхөөрөмж	шинэ	30.0	30.0
23	Малын гаралтай түүхий эдийн мөшгөх тогтолцоог хэрэгжүүлэх /Бүрэнтогтох, Түнэл сум/	ТЭЗҮ	шинэ	80.0	80.0

24	Холбооны худаг сувагчлал, кабель шугамын өргөтгөл /Мөрөн сум/	их засвар	шинэ	150.0	150.0
25	15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалтын ажил /Мөрөн сум/	барилга байгууламж	шинэ	141.0	100.0
26	Энх-Үйлс ӨЭМТ-ийн гадна хашаа барих /Мөрөн сум/	барилга байгууламж	шинэ	19.5	19.5
27	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин тоног төхөөрөмжийг хадгалах байр засварлах ажлын зөвлөх үйлчилгээ	ТЭЗҮ	шилжих	1.2	1.2
28	"Хүүхдийн өрөө"-ний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Шүүхийн тамгын газар/	тоног төхөөрөмж	шинэ	29.5	29.5
НИЙТ ДҮН				4,566.6	2,963.1

Хавсралт № 2

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл арга хэмжээний хэр	Техникийн нөхцөл олгосон эсэх	Урсгал зардал тооцсон эсэх	Өмчлөлд бүртгэх боломжтой эсэх	Нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцсон эсэх	Хэрэгцээ шаардлагад нийцсэн буюу ашиглагч байгууллагын санал авсан эсэх	Зураг, төсөвтэй батлагдсан эсэх
1	6 дугаар багт хийгдсэн ариутгах татуурга, цэвэр бохир усны шугам сүлжээний байгууламжийн траншейны нүхийг таглах, овгор шороонуудыг тэгшлүүлэх	-	-	-	Үгүй	Үгүй	Үгүй
2	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн албан хаагчдын орон сууцны засвар, өргөтгөл хийх	-	-	-	Үгүй	Үгүй	Үгүй
3	"КИОСК" төхөөрөмж болон дагалдах хэрэгслийг худалдан авах /Газрын нэгдсэн систем Е-Монголиа/	-	-	-	Үгүй	Үгүй	-
4	Малын гаралтай түүхий эдийн мөшгөх тогтолцоог хэрэгжүүлэх /Бүрэнтогтох, Түнэл сум/	-	-	Үгүй	Үгүй	Үгүй	-
5	Холбооны худаг сувагчлал, кабель шугамын өргөтгөл /Мөрөн сум/	Үгүй	-	-	Үгүй	Үгүй	Үгүй
6	15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалтын ажил /Мөрөн сум/	-	-	-	Үгүй	Үгүй	-
7	Энх үйлс өрхийн эрүүл мэндийн эмнэлгийн гадна хашаа барих /Мөрөн сум/	-	-	-	Үгүй	Үгүй	Үгүй
8	Эрүүл мэндийн төвийн гадна бохирын шугамын цооногийн ажлын засвар /Тосонцэнгэл сум/	Үгүй	Үгүй	-	Үгүй	Үгүй	Үгүй
9	Ерөнхий боловсролын бага сургуулийн засвар, дулаалга хийлгэх /Хатгал тосгон/	-	-	-	-	Үгүй	Үгүй
10	Эрүүл мэндийн төв, Спорт заалны сантехник тавих, засвар хийх /Бүрэнтогтох сум, Бүрэнхаан баг/	Үгүй	Үгүй	-	Үгүй	Үгүй	Үгүй
11	Гурван гал ӨЭМТ-ийн барилгын дотор сантехник, гадна бохир, усны шугам, сүлжээний их засвар	Үгүй	Үгүй	-	Үгүй	Үгүй	Үгүй
12	Соёлын төвийн дээврийн их засвар /Цагаан-Уул сум/	-	-	-	Үгүй	Үгүй	Үгүй
13	Спорт заалны дээврийн их засвар /Цагаан-Уул сум/	-	-	-	Үгүй	Үгүй	Үгүй
14	Цэцэрлэгийн сантехникийн их засвар /Хатгал тосгон/	-	-	-	Үгүй	Үгүй	Үгүй

15	Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бий болсон машин тоног төхөөрөмж хадгалах байрны засварын дуусгалт /Орон нутгийн өмчийн газар/	-	-	-	Үгүй	Үгүй	-
16	Соёлын төвийн барилгын их засвар /Баянзүрх сум/	-	-	-	Үгүй	Үгүй	Үгүй
17	Спорт соёлын өргөөний барилгын дээврийн засвар /Биеийн тамир спортын газар/	-	-	-	Үгүй	Үгүй	Үгүй
18	Соёлын төвийн барилгын их засвар /Галт сум/ ЕБС-ын 50 хүүхдийн дотуур байрны их засвар болгон өөрчилсөн	-	-	-	Үгүй	Үгүй	-
19	Аймгийн төвийн нэгдсэн эмнэлгийн их засвар	-	-	-	-	Үгүй	-
20	"Хүүхдийн өрөө"-ний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Шүүхийн тамгын газар/	-	-	-	Үгүй	Үгүй	-

Санхүүжилтийн гүйцэтгэл

	Төсвийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Гэрээний үнийн дүн	2023 онд олгосон санхүүжилт
1	1.1.1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар	1,037.4	411.8	Бунбах ХХК	399.0	399.0
2	2.1.1	Ахмадын амралт, сувиллын байрыг төвийн дулааны шугамд холбох /Мөрөн сум/	220.7	70.0	Зураг төсвийн үнэ – Итгэлт чандмань ХХК		8.0
3	2.1.2	Эрүүл мэндийн төвийн гадна бохирын шугамын цооногийн ажлын засвар/Тосонцэнгэл сум/	80.0	80.0	Бунбах ХХК	79.6	79.1
4	2.1.3	Ерөнхий боловсролын сургуулийн бага сургуулийн засвар, дулаалга хийлгэх/Хатгал тосгон/	415.5	300.0	Бунбах ХХК	286.6	286.6
5	2.1.4	Эрүүл мэндийн төв, Спорт заалны сантехник тавих засвар хийх /Бүрэнтогтох сум, Бүрэнхаан баг/	262.6	100.0	Уул-Өвгөд ХХК	99.5	95.7
6	2.1.5	Гурван гал ӨЭМТ-ийн барилгын дотор сантехник, гадна бохир, усны шугам, сүлжээний их засвар	19.1	19.1	Хаш тулгуур ХХК	19.1	18.3
7	2.1.6	Соёлын төвийн дээврийн их засвар /Цагаан-Уул сум/	100.0	100.0	Баяндэ ХХК	99.6	99.6
8	2.1.7	Спорт заалны дээврийн их засвар /Цагаан-Уул сум/	133.2	70.0	Ариун-Ур ХХК	69.8	69.8
9	2.1.8	Цэцэрлэгийн сантехникийн их засвар /Хатгал тосгон/	30.0	30.0	Хаш тулгуур ХХК	30.0	30.0
10	2.1.9	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин тоног төхөөрөмжийг хадгалах байрны засварын дуусгалт /Орон нутгийн өмчийн газар/	6.0	6.0	Хөвсгөл булаг ХХК	6.0	5.9
11	2.1.10	Соёлын төвийн барилгын их засвар /Баянзүрх сум/	65.0	65.0	Ариун-Ур ХХК	64.5	64.5
12	2.1.12	Спорт, соёлын өргөөний барилгын дээврийн засвар /Биеийн тамир спортын газар/	201.4	201.4	Хаш тулгуур ХХК	200.1	200.1
13	2.1.13	Аймгийн төвийн Нэгдсэн эмнэлгийн их засвар	375.7	375.7	Хөвсгөл Мичид ХХК	373.5	362.7
14	1.1.1	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах	156.5	56.5	Туурайн тамга ХХК	153.5	53.5
15	1.1.2	Цэцэрлэгийн гал тогооны засвар /Хатгал тосгон/	50.0	50.0	Хөвсгөл хүрмэн ХХК	49.9	49.9
16	1.1.3	Мод тарьж, Ногоон суварга босгох ажлын хүрээнд хашаа хайс барих шинэчлэл /Мөрөн сум, 5 дугаар баг/	500.0	345.0	Хөвсгөл Эрмүүн оч ХХК	194.7	100.0
		Мод тарьж, Ногоон суварга босгох ажлын хүрээнд хашаа хайс барих шинэчлэл /Мөрөн сум, 8 дугаар баг/			Уул өвгөд ХХК	294.9	245.0
17	1.1.4	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засварын ажлын дуусгалт /Мөрөн сум 8 дугаар баг 15 дугаар байр/	145.0	45.0	Бунбах ХХК	45.0	45.0
18	1.1.5	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засварын ажлын дуусгалт /Мөрөн сум 8 дугаар баг 16 дугаар байр/	145.0	55.0	Бунбах ХХК	55.0	55.0
19	2.1.1	6 дугаар багт хийгдсэн ариутгах татуурга, цэвэр бохир усны шугам сүлжээний байгууламжийн траншейны нүхийг таглах, овгор шороонуудыг тэгшлүүлэх	32.4	32.4	Нью товер ХХК	31.8	30.0
20	2.1.2	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн албан хаагчдын орон сууцны засвар, өргөтгөл хийх	40.0	40.0	Талын хөх сувд ХХК	39.9	39.9
21	2.1.3	"Киоск" төхөөрөмж болон дагалдах хэрэгслийг худалдан авах /Газрын нэгдсэн систем Е-Монголиа/	30.0	30.0	Нью компас ХХК	28.0	28.0

22	2.1.5	Малын гаралтай түүхий эдийн мөшгөх тогтолцоог хэрэгжүүлэх /Бүрэнтогтох, Түнэл сум/	80.0	80.0	Монголын бэлчээр ашиглагчдын холбоо	79.9	79.9
23	2.1.6	Холбооны худаг сувагчлал, кабель шугамын өргөтгөл /Мөрөн сум/	150.0	150.0	Арцатын шанд ХХК	148.3	147.7
24	2.1.7	15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалтын ажил /Мөрөн сум/	141.0	100.0	Сант Өндөр ХХК	140.0	100.0
25	2.1.8	Энх-Үйлс ӨЭМТ-ийн гадна хашаа барих /Мөрөн сум/	19.5	19.5	Тод мөрөн хийц ХХК	19.5	19.2
26	1.1.1	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин тоног төхөөрөмжийг хадгалах байр засварлах ажлын зөвлөх үйлчилгээ	1.2	1.2	Үзэсгэлэнт тайга ХХК	1.5	1.2
27	2.1.1	"Хүүхдийн өрөө"-ний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Шүүхийн тамгын газар/	29.5	29.5	Дөш ган ХХК	29.0	29.0
НИЙТ ДҮН			4,566.6	2,963.1		3,038.1	2,742.5

Хэрэгжиж дууссан боловч нягтлан бодох бүртгэлд тусгасан болон тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	НББ-д бүртгэсэн эсэх	НББ-д бүртгэсэн үнийн дүн
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засвар	1,037.4	үгүй	
2	Эрүүл мэндийн төвийн гадна бохирын шугамын цооногийн ажлын засвар/Тосонцэнгэл сум/	80.0	үгүй	
3	Ерөнхий боловсролын сургуулийн бага сургуулийн засвар, дулаалга хийлгэх/Хатгал тосгон/	415.5	тийм	286.6
4	Эрүүл мэндийн төв, Спорт заалны сантехник тавих засвар хийх /Бүрэнтогтох сум, Бүрэнхаан баг/	262.6	үгүй	
5	Гурван гал ӨЭМТ-ийн барилгын дотор сантехник, гадна бохир, усны шугам, сүлжээний их засвар	19.1	үгүй	
6	Соёлын төвийн дээврийн их засвар /Цагаан-Уул сум/	100.0	үгүй	
7	Спорт заалны дээврийн их засвар /Цагаан-Уул сум/	133.2	үгүй	
8	Цэцэрлэгийн сантехникийн их засвар /Хатгал тосгон/	30.0	үгүй	
9	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин тоног төхөөрөмжийг хадгалах байрны засварын дуусгалт /Орон нутгийн өмчийн газар/	6.0	үгүй	
10	Соёлын төвийн барилгын их засвар /Баянзүрх сум/	65.0	үгүй	
11	Спорт, соёлын өргөөний барилгын дээврийн засвар /Биеийн тамир спортын газар/	201.4	үгүй	
12	Аймгийн төвийн Нэгдсэн эмнэлгийн их засвар	375.7	үгүй	
13	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах	156.5	үгүй	
14	Цэцэрлэгийн гал тогооны засвар /Хатгал тосгон/	50.0	үгүй	
15	Мод тарьж, Ногоон суварга босгох ажлын хүрээнд хашаа хайс барих шинэчлэх /Мөрөн сум, 5 дугаар баг/	500.0	үгүй	
	Мод тарьж, Ногоон суварга босгох ажлын хүрээнд хашаа хайс барих шинэчлэх /Мөрөн сум, 8 дугаар баг/		үгүй	
16	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засварын ажлын дуусгалт /Мөрөн сум 8 дугаар баг 15 дугаар байр/	145.0	НББ-д бүртгэхгүй	
17	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засварын ажлын дуусгалт /Мөрөн сум 8 дугаар баг 16 дугаар байр/	145.0	НББ-д бүртгэхгүй	
18	6 дугаар багт хийгдсэн ариутгах татуурга, цэвэр бохир усны шугам сүлжээний байгууламжийн траншейны нүхийг таглах, овгор шороонуудыг тэгшлүүлэх	32.4	үгүй	
19	"Киоск" төхөөрөмж болон дагалдах хэрэгслийг худалдан авах /Газрын нэгдсэн систем Е-Монголиа/	30.0	үгүй	
20	Малын гаралтай түүхий эдийн мөшгөх тогтолцоог хэрэгжүүлэх /Бүрэнтогтох, Түнэл сум/	80.0	НББ-д бүртгэхгүй	
21	Холбооны худаг сувагчлал, кабель шугамын өргөтгөл /Мөрөн сум/	150.0	үгүй	
22	Энх-Үйлс ӨЭМТ-ийн гадна хашаа барих /Мөрөн сум/	19.5	тийм	19.5
23	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин тоног төхөөрөмжийг хадгалах байр засварлах ажлын зөвлөх үйлчилгээ	1.2	НББ-д бүртгэхгүй	
24	"Хүүхдийн өрөө"-ний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Шүүхийн тамгын газар/	29.5	тийм	29.0
НИЙТ ДҮН		4,064.9		335.1

Холбогдох байгууллагуудын санал:

Санал ирүүлсэн байгууллага, албан тушаалтан	Санал	Санал шийдвэрлэсэн байдал
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ Нутгийн удирдлагын ордон, 3 дөвөр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: (976) 70382764 Факс: (976) 70382554 Цахим шуудан: aimgin@khsgol.gov.mn Цахим хуудас: khovsgol.khural.mn 2024.05.13 № 02/123 танай 2024.05.07 -ны № 01/331 -т Хариу хүргүүлэх тухай Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтыг хянан батлах чиг үүргийн дагуу ажиллаж, хурлын дэргэдэх хяналтын хороо, Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороодын хурлаар тус төслийг оруулж санал, дүгнэлтийг холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлж 2022,2023 онуудын аудитаар өгсөн зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлж, зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах болно.  Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал Удирдлагын хэлтэс Нарийн бичгийн дарга Насанбуян Төмөрхуяг 2024-05-13 14:52:04	Санал ирүүлээгүй
Аймгийн Засаг дарга	 МОНГОЛ УЛС ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001 Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn Цахим хуудас: www.khovsgol.gov.mn 2024.05.09 № 1/881 танай -ны № -т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллана.  П.ЛХАГВАЖАВ  My Doc! jīg toot 6712030800	Санал ирүүлээгүй

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 70383303 Факс: Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn Цахим хуудас: https://khovsgol.gov.mn/ 2024.05.09 № 3/877 танай _____ -ны № _____ -т Г ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллана.  Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар Засаг даргын тамгын газар Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бямбажав Батбилгүүн 2024-05-09 15:44:44	Санал ирүүлээгүй
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 70383303 Факс: Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn Цахим хуудас: https://khovsgol.gov.mn/ 2024.05.09 № 6/878 танай _____ -ны № _____ -т Г ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллана.  Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс Хэлтсийн дарга Батмөнх Оюунтуяа 2024-05-09 16:43:27	Санал ирүүлээгүй

Орон нутгийн өмчийн газар	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР АЗДТГ-ын байр А корпус 1 давхар 8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 2348, факс: 7038 2348 Цахим шуудан: Umchiingazar@khs.gov.mn Цахим хуудас: http://umch.khs.gov.mn 2024.05.09 № 1/184 танай 2024.05.07 -ны № 01/335-т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно. ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ЦЭНД-АЮУШ DocSign tool 6712030113	Санал ирүүлээгүй
Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ	 ХӨВСГӨЛ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ТӨВ ААТҮГ Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 3353 2024.05.07 № 02/49 танай 2024.05.07 -ны № 01/336-т ХӨСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Танай байгууллагаас ирүүлсэн “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Дээрх төсөлтэй холбоотойгоор тухайлсан саналгүй болно. ЗАХИРАЛ  Х.ДАВААСҮРЭН 45 4143321	Санал ирүүлээгүй



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 15 өдөр

№ 81/А227/0437/ХӨА-2024/28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Өмнөх онд гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн “Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, саналд үндэслэсэн, ач холбогдолтой, олон нийтийн саналыг авч эрэмбэлэгдсэн, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг батлах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бөгөөд 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөлтийн (техникийн нөхцөл олгогдоогүй, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй) шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталсан зөрчил давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3. “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.” Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 “Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ баталсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;

2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг батлан, хэрэгжүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Мөнгөнхуяг)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Н.ГҮРБАЗАР

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

6724030298



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 15 өдөр

№ 82/А2270437/ХӨА-2024/28-21-ШТА-ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн “Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, саналд үндэслэсэн, нийцсэн, ач холбогдолтой, олон нийтийн саналыг авч эрэмбэлэгдсэн, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг батлах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бөгөөд 2023 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар төлөвлөлтийн (техникийн нөхцөл олгогдоогүй, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, урсгал зардал тооцоогүй, нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй, байгууллагын өмчлөлд бүртгэх боломжгүй) шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн зөрчил давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3. “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн орон нутгийн төсөвт тусгаж, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргад (П.Лхагважав)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Н.ГҮРБА ЗАР

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

6724030301



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 15 өдөр

№ 83/12270438/2024-2024/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн “Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд, хэрэгжилт үр дүнг хариуцах хууль, журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг захиалагч (Засаг дарга), мэргэжлийн чиг үүрэг бүхий Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс боловсруулаагүй зөрчил давтагдан гарсан байна. Тухайлбал:

1. “Хүүхдийн өрөө”-ний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Шүүхийн тамгын газар/ төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Шүүхийн тамгын газар, “Киоск” төхөөрөмж болон дагалдах хэрэгслийг худалдан авах /Газрын нэгдсэн систем Е-Монголиа/ төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар тус тус боловсруулсан.

2. 2024 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан Тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Биеийн тамир спортын газар, Аймгийн Засаг даргын Тамгын газарт Тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт Авто машин худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Хууль эрх зүйн хэлтэс зэрэг өөр газар, хэлтсүүд боловсруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна.”, 12 дугаар зүйлийн 12.1-т “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

6724030308

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын техникийн тодорхойлолт, гэрээг Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс чиг үүргийн дагуу боловсруулахгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг дарга (П.Лхагважав), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа) нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

З.ДАВААДОРЖ



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 15 өдөр

№ 84/22270437/ХӨА-2024/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн Мөрөн сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалтын /Мөрөн сум/ ажлаас хүүхдийн цэцэглэгийн хичээлийн байр буюу бүлгийн өрөө болон ариун цэврийн өрөөнд зураг төсөвт заасан хамар ханын ажлыг хийж гүйцэтгээгүй, дотор заслын ажилд зураг төсөвт зааснаас өөр материал ашиглахдаа зохиогчоос тухайн үед зөвшөөрөл аваагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. “Барилгын материал, бүтээгдэхүүнийг барилгын ажлын явцад захиалагч, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн зураг төсөл зохиогчийн шийдвэрээр өөрчилнө.”, 37 дугаар зүйлийн 37.1.5. “барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэхдээ гэрээнд заасан захиалагчийн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, зураг төсөвт заасан хамар ханын ажлыг хийж гүйцэтгүүлэн биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

6724030205

2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламжийн ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэх, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон материал, хийц, бүтээц, эдлэхүүнийг ашиглаж байгаад хяналт тавьж ажиллахыг аймгийн Барилга захиалагчийн хяналтын төвийн дарга (Х.Даваасүрэн), хяналтын инженерүүдэд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Н.ПҮРБАЗАР

